



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/66/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Сайншанд сум 2022 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас:70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Т.Оюунтуяа Утас: 99048991 Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн төрийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншинд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@aadit.gov.mn

2023.02.24 № 14/2023

таний _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 950.7 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 799.5 сая төгрөгийн 35 гүйлгээ, 21.7 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113.05 сая төгрөгийн орлогын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 16.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван

01000049

сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх гэсэн өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт биелээгүй байна. Энэ нь тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 47 харилцагчдаас 110.1 сая төгрөгийн худалдан авалтад төлбөрийн цахим баримт аваагүй ба ихэнх ажил гүйлгээнд цахим нэхэмжлэх авдаггүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоо; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг 5 сард нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Малын тоо толгойн албан татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн "5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна", "7.3.Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ" заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус газрын үндсэн хөрөнгөд 2016 оноос хойш бодитоор оршин байхгүй 23.2 сая төгрөгийн хийлдэг байгууламжийн их бие, хийлэгч эд анги бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ.", 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалтуудтай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зарим хөрөнгүүдэд 7.4 сая төгрөгөөр илүү, 1.7 сая төгрөгөөр дутуу тооцогдсон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7-д "нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 16 зорилт, 76 арга хэмжээний хэрэгжилт 92.4 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.4 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 108,539,989.70 | 105,807,008.71 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 7,600,000.00 | 9,300,000.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 7,600,000.00 | 9,300,000.00 |
| 3121 | Төгрөг | 7,600,000.00 | 9,300,000.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 7,600,000.00 | 9,300,000.00 |
| 33 | АВЛАГА | 7,629,403.49 | 4,255,792.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6,582,057.49 | 3,391,824.00 |
| 335 | Бусад авлага | 1,047,346.00 | 863,968.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,047,346.00 | 63,968.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 800,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 93,310,586.21 | 92,251,216.71 |
| 351 | Түүхий эд материал | 1,468,215.00 | 673,700.00 |
| 35130 | Эм боох материал | 1,468,215.00 | 673,700.00 |
| 354 | Хангамжийн материал | 83,262,371.21 | 78,387,516.71 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,079,150.00 | 7,274,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 62,282,781.00 | 59,499,466.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,770,000.00 | 1,770,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 11,734,740.01 | 3,975,700.01 |
| 35460 | Хүнсний материал | 3,395,700.20 | 5,868,250.20 |
| 35600 | Мал амьтад | 8,580,000.00 | 13,190,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,454,272,309.87 | 3,300,181,982.35 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,454,272,309.87 | 3,300,181,982.35 |
| 392 | Биет хөрөнгө | 2,880,418,210.03 | 2,727,086,782.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,920,914,713.75 | 2,920,639,756.75 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -214,248,047.15 | -329,973,090.19 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 60,148,000.00 | 20,150,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -52,388,000.04 | -4,330,000.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 301,758,792.67 | 140,238,885.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -220,928,507.84 | -71,781,576.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 239,690,077.00 | 192,615,977.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -154,528,818.36 | -140,473,169.23 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,766,594.00 | 1,175,850.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,766,594.00 | -1,175,850.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 573,854,099.84 | 573,095,199.68 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 574,613,000.00 | 574,613,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -758,900.16 | -1,517,800.32 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,562,812,299.57 | 3,405,988,991.06 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 409,613.50 | 4,912,671.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 409,613.50 | 4,912,671.00 |
| 413 | Өглөг | 409,613.50 | 4,912,671.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 4,754,015.00 |
| 4136 | Бусад өглөг | 409,613.50 | 158,656.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 409,613.50 | 50,400.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 108,256.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,562,402,686.07 | 3,401,076,320.06 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,562,402,686.07 | 3,401,076,320.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 756,435,814.51 | 756,435,814.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 756,435,814.51 | 756,435,814.51 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,785,300,035.56 | 2,644,640,505.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,785,300,035.56 | 2,805,798,871.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -161,158,366.01 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 20,666,836.00 | 00.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,562,812,299.57 | 3,405,988,991.06 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,012,722,010.00 | 949,236,209.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 137,313,600.00 | 26,969,136.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 137,313,600.00 | 26,969,136.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 137,313,600.00 | 26,969,136.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 127,936.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 137,313,600.00 | 21,841,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,408,410.00 | 922,267,073.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 856,347,200.00 | 853,302,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 856,347,200.00 | 853,302,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 19,061,210.00 | 68,964,473.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,079,710.00 | 40,679,173.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,500,000.00 | 27,285,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,481,500.00 | 1,000,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,263,764,765.34 | 1,110,163,825.01 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,263,764,765.34 | 1,110,163,825.01 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,248,374,821.85 | 1,056,920,728.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 601,224,443.51 | 516,420,287.55 |
| 210101 | Үндсэн цалин | 455,914,699.00 | 516,420,287.55 |
| 210102 | Нэмэгдэл | 110,938,746.04 | 00.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,370,998.47 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,341,882.51 | 143,248,219.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,341,882.51 | 139,239,956.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 4,008,263.49 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,458,176.00 | 84,592,231.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,392,743.00 | 9,700,215.00 |
| 210302 | Түлш, халаалт | 54,686,333.00 | 63,357,580.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,379,100.00 | 11,534,436.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,642,465.00 | 37,498,490.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,034,350.00 | 6,140,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 180,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,187,547.00 | 2,570,079.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,230,500.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,010,068.00 | 28,548,361.50 |
| 2105 | Нормативт зардал | 156,316,792.50 | 39,098,483.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,583,040.00 | 1,401,365.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,924,752.50 | 37,697,118.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120,809,000.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 775,500.00 | 858,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 43,400.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 732,100.00 | 858,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,450,500.00 | 2,757,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,450,500.00 | 2,757,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,740,920.00 | 52,536,539.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 30,749,029.00 | 48,201,114.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,576,000.00 | 2,324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 704,000.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,700.00 | 855,725.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 135,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 950,191.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | 1,020,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 277,424,142.33 | 179,910,777.52 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,583,825.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол | 274,840,317.33 | 179,910,777.52 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,389,943.49 | 53,243,096.45 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,185,000.00 | 7,461,048.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,185,000.00 | 7,461,048.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 14,204,943.49 | 45,782,048.45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,204,943.49 | 45,782,048.45 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -251,042,755.34 | -160,927,616.01 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 230,750.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 230,750.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 00.00 | -161,158,366.01 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 875,408,410.00 | 927,439,297.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 5,063,968.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 5,063,968.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 5,063,968.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 63,968.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 875,408,410.00 | 922,375,329.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 856,347,200.00 | 853,302,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 856,347,200.00 | 853,302,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 19,061,210.00 | 69,072,729.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,079,710.00 | 40,679,173.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,500,000.00 | 27,285,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,481,500.00 | 1,108,256.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 871,070,510.00 | 916,919,297.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 871,070,510.00 | 916,919,297.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 855,680,566.51 | 862,542,940.55 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 604,293,214.51 | 573,166,234.55 |
| 210101 | Үндсэн цалин | 459,199,724.00 | 425,714,868.29 |
| 210102 | Нэмэгдэл | 110,722,492.04 | 97,141,544.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,370,998.47 | 38,034,189.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,275,633.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,660,690.00 | 76,671,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,660,690.00 | 76,671,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 74,680,072.00 | 68,549,730.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,710,093.00 | 9,700,215.00 |
| 210302 | Түлш, халаалт | 60,590,879.00 | 52,820,725.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,379,100.00 | 6,028,790.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,988,108.00 | 24,188,739.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,141,500.00 | 9,225,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 | 3,141,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,154,378.00 | 2,442,919.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,230,500.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,661,730.00 | 9,138,720.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,369,629.00 | 56,539,169.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,358,300.00 | 347,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,261,979.00 | 48,311,144.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,749,350.00 | 7,881,025.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,186,900.00 | 1,838,750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 159,900.00 | 709,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,227,000.00 | 1,128,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 482,500.00 | 3,267,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 27,467,230.00 | 58,321,818.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусдаажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,442,039.00 | 53,576,893.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,576,000.00 | 2,324,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 704,000.00 | 747,525.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 128,700.00 | 108,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 983,491.00 | 490,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 600,000.00 | 1,020,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,552,223.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,584,223.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,968,000.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,389,943.49 | 54,376,356.45 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,185,000.00 | 8,594,308.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,185,000.00 | 8,594,308.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 14,204,943.49 | 45,782,048.45 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,204,943.49 | 45,782,048.45 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 4,337,900.00 | 10,520,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 4,337,900.00 | 8,820,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,337,900.00 | 8,820,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,337,900.00 | 8,820,000.00 |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 4,337,900.00 | 8,820,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -4,337,900.00 | -8,820,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 1,700,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 100,000.00 | 7,600,000.00 |

| | | | |
|----|---|-------|--------------|
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 9,300,000.00 |
|----|---|-------|--------------|

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 189,411,814.51 | 19,771,016.00 | 280,904,705.36 | 490,087,535.87 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 3,969,159.00 | 3,969,159.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 189,411,814.51 | 19,771,016.00 | 284,873,864.36 | 494,056,694.87 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 19,771,016.00 | 63,212,718.91 | 82,983,734.91 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | 20,666,836.00 | 2,785,300,035.56 | 3,562,402,686.07 |
| D01 | 2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | 20,666,836.00 | 2,785,300,035.56 | 3,562,402,686.07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 20,498,836.00 | 20,498,836.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 756,435,814.51 | 20,666,836.00 | 2,805,798,871.56 | 3,582,901,522.07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 20,666,836.00 | 00.00 | -20,666,836.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -161,158,366.01 | -161,158,366.01 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 756,435,814.51 | 00.00 | 2,644,640,505.55 | 3,401,076,320.06 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|-----------------------|--|-----------------------|----------------|-----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 7,600,000.00 | (7,600,000.00) |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 898,186,400.00 | 925,739,297.00 | (27,552,897.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 898,186,400.00 | 925,739,297.00 | (27,552,897.00) |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 897,001,200.00 | 871,362,940.55 | 25,638,259.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 613,388,100.00 | 573,166,234.55 | 40,221,865.45 |
| 210101 | Үндсэн цалин | 464,024,700.00 | 425,714,868.29 | 38,309,831.71 |
| 210102 | Нэмэгдэл | 102,421,400.00 | 97,141,544.26 | 5,279,855.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 46,942,000.00 | 38,034,189.00 | 8,907,811.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,275,633.00 | (12,275,633.00) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 76,673,600.00 | 76,671,500.00 | 2,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 76,673,600.00 | 76,671,500.00 | 2,100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 67,789,800.00 | 68,549,730.00 | (759,930.00) |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,930,100.00 | 9,700,215.00 | 229,885.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,556,400.00 | 52,820,725.00 | (264,325.00) |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,303,300.00 | 6,028,700.00 | (725,400.00) |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,023,700.00 | 24,988,739.00 | (9,965,039.00) |
| 210401 | Бичиг хэрэг | 1,698,800.00 | 9,225,700.00 | (7,526,900.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,775,100.00 | 3,141,400.00 | (366,300.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,219,300.00 | 2,442,919.00 | (223,619.00) |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 621,900.00 | 240,000.00 | 381,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,708,600.00 | 9,938,720.00 | (2,230,120.00) |
| 2105 | Нормативт зардал | 69,967,600.00 | 56,539,169.00 | 13,428,431.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 543,700.00 | 347,000.00 | 196,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 60,963,600.00 | 48,311,144.00 | 12,652,456.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,460,300.00 | 7,881,025.00 | 579,275.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,825,400.00 | 9,068,750.00 | 756,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,628,000.00 | 7,939,900.00 | 688,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,197,400.00 | 1,128,850.00 | 68,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 8,100.00 | 3,267,000.00 | (3,258,900.00) |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,100.00 | 3,267,000.00 | (3,258,900.00) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,324,900.00 | 59,111,818.00 | (14,786,918.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 39,281,300.00 | 54,366,893.00 | (15,085,593.00) |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,324,000.00 | 2,324,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,045,500.00 | 747,525.00 | 297,975.00 |

| | | | | |
|---------------|---|-----------------------|-----------------------|------------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 108,200.00 | 108,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,400.00 | 55,000.00 | 400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 490,300.00 | 490,000.00 | 300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,020,200.00 | 1,020,200.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1185200.00 | 8594308.00 | (7,409,108.00) |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,185,200.00 | 8,594,308.00 | (7,409,108.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,185,200.00 | 8,594,308.00 | (7,409,108.00) |
| 21 | Олгосон санхүүжилт шилжүүлэг | | 45,782,048.45 | (45,782,048.45) |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төлөрүүлэх шилжүүлэг | | 45,782,048.45 | (45,782,048.45) |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 898,186,400.00 | 927,439,297.00 | (29,252,897.00) |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 898,186,400.00 | 853,302,600.00 | 44,883,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 898,186,400.00 | 853,302,600.00 | 44,883,800.00 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 00.00 | 5,063,968.00 | (5,063,968.00) |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 63,968.00 | (63,968.00) |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,000,000.00 | (5,000,000.00) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 69,072,729.00 | (69,072,729.00) |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 40,679,173.00 | (40,679,173.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 27,285,300.00 | (27,285,300.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,108,256.00 | (1,108,256.00) |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 7,600,000.00 | (7,600,000.00) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 9,300,000.00 | (9,300,000.00) |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 55.00 | 55.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 36.00 | 36.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18.00 | 18.00 | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|---|-------------|----------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 69,072,729.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 69,072,729.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 63,497,453.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 760,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 760,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 11,084,830.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,521,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,950,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,613,830.00 |
| 2105 | Нормативт зардал | | 7,794,240.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 199,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 7,540,890.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 54,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 3,267,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 3,267,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 40,591,383.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 40,591,383.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 4114308.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 4,114,308.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,114,308.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 1,460,968.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,460,968.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 69,072,729.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 69,072,729.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 40,679,173.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 27,285,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,108,256.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26.7 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 26.7 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдэл 20.7 сая төгрөгөөр илүү бүртгэснийг;
2. Тайлант хугацааны жилийн эцсийн тооллогоор 0.8 сая төгрөгийн хөрөнгө дутагдсаныг авлагаар бүртгээгүй байсныг;
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн ахмадын сангийн 5.0 сая төгрөг, нэр данс зөрүү 0.2 сая төгрөгийн гүйлгээг орлогоор бүртгэснийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 7 зөрчил² илэрснээс 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 950.7 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 799.5 сая төгрөгийн 35 гүйлгээ, 21.7 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113.05 сая төгрөгийн орлогын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 16.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлттэй холбоотой асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх гэсэн өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт биелээгүй байна. Энэ нь хөрөнгийн дүн бодитоор илэрхийлэгдэхгүй байх үр дагавартай.

Мөн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.1-д энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 47 харилцагчдаас 110.1 сая төгрөгийн худалдан авалтад төлбөрийн цахим баримт аваагүй ба ихэнх ажил гүйлгээнд цахим нэхэмжлэх авдаггүй байна. нь эргэлзээтэй байна. Энэ нь зардал бодитоор гарсан эсэх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-ын тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтын төлбөр тооцоо хийгдэхээс өмнө цахим нэхэмжлэх авч, тооцоо хийгдсэн тухай бүрд нь төлбөрийн цахим баримт болгож санхүүгийн тайланд тусгаж ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг 5 сард нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. Энэ нь НД-ын байгууллагад үнэн зөв тайлагнаагүйгээс үүссэн зөрүүнд нөхөн шимтгэл, торгууль тавигдах үр дагавартай.

Мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 “Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор” шимтгэл ногдуулах орлогын бүрэлдэхүүнд орно” заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг нийгмийн даатгалын байгууллагад үнэн зөв тайлагнаж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

3. Татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна. Энэ нь бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлага бодитоор илэрхийлэгдэхгүй, санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх үр дагавартай.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн “5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”, “7.3.Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ” гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгөд 2016 оноос хойш бодитоор оршин байхгүй 23.2 сая төгрөгийн хийлдэг байгууламжийн их бие, хийлэгч эд анги бүртгэлтэй байна. Энэ нь хөрөнгийн үлдэгдэл бодит бусаар илэрхийлэгдэх үр дагавартай.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ.”, 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” заалтуудтай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгөтэй холбогдох асуудлыг шийдвэрлэж, хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах

5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд зарим хөрөнгүүдэд 7.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал илүү, 1.7 сая төгрөг дутуу тооцогдсон. Энэ нь хөрөнгийн үлдэгдэл бодитоор илэрхийлэгдэхгүй байх үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцож бүртгэх, хяналтыг хэрэгжүүлэх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Дахин үнэлгээний нэмэгдэл 20.7 сая төгрөгөөр илүү бүртгэсэн. | 1 | 20,666.8 | | | 1 | 20,666.8 | 1 | 20,666.8 | | | | |
| Тайлант хугацааны жилийн эцсийн тооллогоор 0.8 сая төгрөгийн хөрөнгө дутагдсаныг авлагаар бүртгээгүй. | 1 | 800.0 | | | 1 | 800.0 | 1 | 800.0 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн ахмадын сангийн 5.0 сая төгрөг, нэр данс зөрүү 0.2 сая төгрөгийн гүйлгээг орлогоор бүртгэсэн | 1 | 5,172.2 | | | 1 | 5,172.2 | 1 | 5,172.2 | | | | |
| Дүн | 3 | 26,639.0 | | | 3 | 26,639.0 | 3 | 26,639.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|----------|-----------------|----------|---------|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 950.7 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 799.5 сая төгрөгийн 35 гүйлгээ, 21.7 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 113.05 сая төгрөгийн орлогын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 16.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | - | - | 1 | - | | |
| Дүн | 1 | | - | - | 1 | - | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|---------|----------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлаж данснаас хасах, дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх гэсэн өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт биелээгүй байна. | 1 | | | | 1 | | | | | | | |
| Анхан шатны баримтын тулгалтаар 47 харилцагчдаас 110.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй, ихэнх ажил гүйлгээнд цахим нэхэмжлэх авдаггүй байна. | 1 | | | | | | | 1 | | | | |
| Тус байгууллагын ажилтны 0.2 сая төгрөгийн цалин хөлсийг 5 сард нийгмийн даатгалд тайлагнаагүй байна. | 1 | | | | | | | 1 | | | | |
| Илрүүлэлтээр малын тоо толгойн албан татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна. | 1 | | | | | | | 1 | | | | |
| Тус газрын үндсэн хөрөнгөд 2016 оноос хойш биетээр байхгүй 23.2 сая төгрөгийн хийлдэг байгууламжийн их бие, хийлэгч эд анги бүртгэлтэй байна. | 1 | 23,150.0 | | | | | | 1 | | | | |
| Тайлант онд зарим хөрөнгүүдэд 7.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал илүү, 1.7 сая төгрөг дутуу тооцогдсон. | 1 | | | | | | | 1 | | | | |
| Дүн | 6 | | | | 1 | | | 5 | | | | |